



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЦЭНГҮҮН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.09.15 № МХ/2498

танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж ирүүлсэн эрчим хүчний реформын талаарх асуулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 09 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255013236

Эрчим хүчний реформын талаар

Асуулга-1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3-т тусгагдсан “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал”-ыг Ерөнхий сайдын хувьд үргэлжлүүлэх эсэх:

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3-т тусгагдсан “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал”-ыг үргэлжлүүлэхээр Монгол Улсын Засгийн газар ажиллаж байна. Эрчим хүчний салбар Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий суурь салбар тул хууль эрх зүйн орчныг шинэчлэх, зарим аж ахуйн нэгжийг хувьчлах, эрчим хүчийг тасралтгүй найдвартай үйлдвэрлэх, цахилгаан, дулааны үнийг аль болох өртөг багатай байлгах зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Асуулга-2. “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал”-ын бодлогын хүрээнд хүрэх зорилго, шийдэх алхамууд, цаг хугацааны дараалал, шаардагдах хөрөнгө, санхүүг тодорхойлж, улсын төсөвт тусгасан эсэх:

“Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал”-ын бодлогын хүрээнд Монгол Улсын онцлогт тохирсон, эрчим хүчний салбарын реформыг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд, (1) үнэ тарифын шинэчлэлт хийх, (2) салбарын бүтцийн реформ хийнэ.

1. Үнэ тарифын шинэчлэлтийг эхний ээлжинд салбарын алдагдлыг өртгөөрөө нөхөх хэмжээнд хүргэх, хэрэглэгчийн тарифыг эрчим хүчний үйлдвэрлэлийн өртөгт нь нийцүүлэх, цаашид тогтмол индексжүүлж байхаар шийдвэрлэн, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний дундаж тарифыг 30 хувиар нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан байна. Дулааны үнийг 2025 оны эхний хагас жилээр нэмэгдүүлэхээр шийдвэрлэснийг түр хойшлуулсан байна.

2. Эрчим хүчний салбарын бүтцийн реформыг эрчим хүчний зах зээлийн загварыг тодорхойлсноор хийх нь зүйтэй бөгөөд одоо ашиглаж буй нэг худалдан авагчтай зах зээлийн загварыг цаашид шинэчлэх шаардлага, бөөний зах зээлд шилжих боломжийн нөхцөл байдлын шинжилгээг хийж байна. Харьцангуй бага хүн амтай, үйлдвэрлэл хөгжөөгүй байгаа хязгаарлагдмал зах зээлийн одоогийн орчинд өрсөлдөөн үүсгэх боломжийг эрэлхийлж байна. Энэ хүрээнд, ойрын хугацаанд улсын хэмжээнд төлөвлөгдөж буй бүтээн байгуулалтын төслүүдийн эрчим хүчний эрэлт, эрчим хүчний салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд бий болох нийлүүлэлтийн харьцааг тооцох, олон улсын сайн туршлагуудыг судлах шаардлагатай байна.

Эрчим хүчний зах зээлийн дараагийн загварыг тодорхойлсноор эрчим хүчний зах зээл дээрх оролцогч талуудын чиг үүрэг, хариуцлага тодорхой болж, эрчим хүчний салбарт хийх бүтцийн реформын үндсэн зураглал гарах ба эрх зүйн орчин, эрчим хүчний тухай хуулийг шинэчлэх үзэл баримтлал бий болно.

Энэ чиглэлээр, Эрчим хүчний яам Азийн хөгжлийн банкт хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагааны хүрээнд салбарын зах зээлийн орчныг сайжруулах, Монголын

эрчим хүчний зах зээлийг өрсөлдөөнт зах зээл рүү шилжүүлэх судалгааны ажлыг Гүрж улсын зөвлөхүүдтэй хамтран хийж байна. Тус ажлын хэсэг 2025 оны 10 дугаар сарын 30-нд нэгтгэсэн тайлан, зөвлөмжийг ирүүлэх ба тус тайлан, зөвлөмжийг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан Улсын Их Хурлын гишүүдийн бүрэлдэхүүн бүхий Ажлын хэсэгт танилцуулна.

Асуулга-3. Эрчим хүчний зах зээлийн нэг худалдан авагчийн загварын талаар баримталж буй бодлого, уг зах зээлийн загварыг өөрчлөх бол цаг хугацааны тооцоолол хийсэн эсэх:

Эрчим хүчний тухай хууль 2001 онд шинэчлэгдэн батлагдаж, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааг нэг хуулийн этгээд хариуцаж байсан удирдлагын босоо, төвлөрсөн тогтолцоог задалж үйл ажиллагааны чиглэлээрээ онцлог бүхий бие даасан компаниудыг байгуулсан.

Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын хувь нийлүүлэгчдийн 2002 оны 25 дугаар тогтоол, Дэд бүтцийн сайд (хуучин нэрээр)-ын 2002 оны 240 дүгээр тушаалын дагуу 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс төвийн бүсийн цахилгааны нэгдсэн сүлжээний хүрээнд Нэг худалдан авагчтай зах зээлийн загварыг эрчим хүчний компаниудын арилжааны болон мөнгөний урсгалын зохицуулалтад ашиглаж байна.

Харин уг зах зээл дээрх үнэ болон худалдах ба худалдан авах эрчим хүчний биет хэмжээ өрсөлдөөнд суурилж чөлөөтэй тогтодоггүй бөгөөд өөрөөр хэлбэл зах зээл дээрх бүх үнэ, тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоож, үйлдвэрлэлийн биет хэмжээ, түүний төлөвлөгөөг Диспетчерийн үндэсний төв боловсруулж байна.

Цаашид үнэ, тарифыг чөлөөлсөн нөхцөлд Нэг худалдан авагчтай загвар бүхий өнөөгийн төрийн зохицуулалттай тогтолцоог нийт зах зээлийн тодорхой хэсэгт хэвээр үлдээж, үүний зэрэгцээ 1) бодит өрсөлдөөн бүхий Нэг худалдан авагчтай зах зээл, 2) Хоёр талын гэрээт болон 3) жижиглэнгийн зах зээлийг хөгжүүлж, эдгээрийн зах зээлд эзлэх хувь хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, холимог бүтэц бүхий зах зээлийн тогтолцоонд шилжих нь зүйтэй юм.

Монгол Улсын хувьд эрчим хүчний зах зээлийн төвлөрлийн индекс (Herfindahl-Hirschman Index-HHI) өндөр, шинээр хэрэгжих хувийн хөрөнгө оруулалттай цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх төслүүд төслийн санхүүжилтээ шийдвэрлэх үүднээс урт хугацааны тогтвортой үнэ бүхий “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-нүүд байгуулагдсан хэдий ч одоогийн хууль эрх зүйн орчинд энэ талаар зохицуулалт байхгүй зэргээс шалтгаалан тус салбарын зах зээлийг бүрэн чөлөөлөх, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд бүрэн шилжихэд цаг хугацаа орох ба үе шаттайгаар хэрэгжилтийг хангах шаардлагатай болж байна.

Нэг худалдан авагчтай загварын үйл ажиллагаа: Эрчим хүчний салбарын цахилгааны зах зээлийн “Нэг худалдан авагчтай /цаашид НХА гэх/ загвар” нь мөнгөний урсгалыг зохицуулах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төвлөрүүлсэн орлогыг “Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данс”-нд хуримтлуулж, Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан коэффициентийн дагуу үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч рүү тухайн өдөр бүр автомат системээр хуваарилагддаг.

НХА-тай зах зээлийн загвар нь эрчим хүчний салбарын хүнд хэцүү үеийн даван туулж, хөгжихөд зохистой үүрэг гүйцэтгэсэн. Салбарын санхүүгийн байдлыг

тогтворжуулснаар системийн найдвартай ажиллагааг хангахад зохих хувь нэмэр оруулсан гэж үздэг. Уг загварыг одоогоор Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ашиглаж байна.

Дараах хүснэгтэд одоогийн НХА-тай загварын давуу болон сул талыг харуулав:

НХА-тай загварын давуу талууд	НХА-тай загварын сул талууд
- Харьцангуй энгийн - Орлого төвлөрүүлэлт сайжирсан - Үйлдвэрлэгчдэд төлөх төлбөр нэмэгдсэн - Хэрэглэгчийн эрчим хүчний төлбөрийг зохисгүй байдлаар зарцуулах боломжийг хязгаарлаж бууруулсан - Компаниудын санхүүгийн байдлыг тогтворжуулсан - Өглөг, авлагыг бууруулсан	- Төрөөс зохицуулалттай - Түгээх сүлжээнүүдэд орлого төвлөрүүлэлтийг сайжруулах сонирхол бага - Үнэ тарифыг хатуу барьдаг - Арилжааны загвар боловч зөвхөн төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулдаг - НХА-тай зах зээлийн харилцаа сонгодог утгаараа хэрэгжээгүй - Зах зээлийн бусад загварыг нэвтрүүлэх боломж хязгаарлагдмал

Эрчим хүчний салбар нь НХА-тай загвараас эрчим хүчний бөөний зах зээл рүү шилжих бодлого баримталж байна. Эх үүсгүүрүүдийн үнийг чөлөөт зах зээлийн зарчим дээр үндэслэн тогтоох эрх зүйн зохицуулалт үүссэнээс хойш 1-2 жилийн дотор эрчим хүчний бөөний зах зээлийг нэвтрүүлэн нэг өдрийн өмнөх ба нэг цагийн доторх арилжааг зохион байгуулдаг болох боломжтой.

Асуулга-4. Эрчим хүчний салбарт чөлөөт зах зээлийн зарчмыг баримталж төрийн төвлөрсөн монопол системийг задлах, төрөөс хувийн сектор руу шилжүүлэх бодлогын хүрээнд төрийн өмчит эрчим хүчний компаниудыг хувьчлах, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийг бие даан ажиллах боломжоор хангах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих эсэх, тархмал эх үүсвэрийн тогтолцоо болон эрчим хүчний технологи, сүлжээний шинэчлэлийг дэмжих эсэх:

Монгол Улсын төвийн бүсийн цахилгааны нэгдсэн сүлжээнд үйл ажиллагаа эрхлэгч эрчим хүчний компаниудыг үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч тус бүрээр хуулийн этгээдийн бүтцийн өөрчлөлт (legal unbundling) хийж задлан тус тусдаа хувьцаат компани байгуулж, нэг худалдан авагчтай загвар бүхий бөөний зах зээлийн хэв шинжийг агуулан 20 гаруй жил ажиллаж байна.

Олон улсын жишгээс авч үзвэл эрчим хүчний салбарт чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжиж, монополыг бүрэн задлахын тулд өмчлөлийн бүтцийн өөрчлөлт (ownership unbundling) хийн хувьчлалыг хэрэгжүүлэх шаардлагатай. Төрийн өмчийг хувьчлахаас гадна төр өмчөө хадгалсан хэвээр компанийн удирдлагын функцийг хувийн хэвшилд шилжүүлэх байдлаар хэрэгжүүлэх тохиолдол ч байдаг.

Эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явц 1996 оноос эхэлсэн ба засвар үйлчилгээний компаниудыг хувийн хэвшилд шилжүүлсэн. Дараа нь 2001 оны хуулиар эрчим хүчний төрийн өмчит үйлдвэрүүдийг зах зээлийн зарчмаар ажиллуулах болон өмч хувьчлалын бодлоготой уялдуулан хувьцаат компаниуд болгон зохион байгуулсан байна.

Эрчим хүчний үнийг бүрэн чөлөөлөх боломжийг бүрдүүлээгүйгээс салбар зах зээлийн харилцаанд бүрэн шилжээгүй, бүтээгдэхүүний үнэ хөрөнгө оруулагчдын сонирхлыг төрүүлдэггүйгээс эрчим хүч үйлдвэрлэх эх үүсвэрийн дутагдалд орсон байна. Шинэ технологийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулагчдын сонирхлыг бий болгохын тулд 2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг баталж, энэ чиглэлийн үйл ажиллагаанд дэмжих тарифыг нэвтрүүлснээр нар, салхины эх үүсвэрүүдийг барих хөрөнгө оруулагчид олноор гэрээ байгуулсан нь мөн л үнэ тарифыг чөлөөлж амжаагүй, нөгөө талаас үйлдвэрлэл хэрэглээ нэг агшинд явдаг эрчим хүчний системийн онцлогоос хамааран шингээх чадвар дутагдан өнөөдрийг хүрсэн байна.

Дээрх 20 жилийн үйл ажиллагааны явц, бусад чөлөөт зах зээл бүхий улс орнуудын туршлагааас харахад, эрчим хүчний ямар ч зах зээлийн загвар үйлчлэх байсан монопол дэд бүтэц болох дамжуулах, түгээх шугам сүлжээнд төрийн зохицуулалтыг өндөр байлгах нь зүйтэй байгаа ба харин эрчим хүч үйлдвэрлэх болон борлуулах үйлчилгээг өмчийн ямар ч хэлбэрт шилжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Одоогийн байдлаар эрчим хүчний салбарын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх компаниудын 6 нь төрийн өмчтэй, 12 хувийн компани байна. Эдгээрийн дийлэнх нь сэргээгдэх эрчим хүчний компаниуд байна. Нийт 27 төрийн өмчит компанийн 6 нь үйлдвэрлэгч, дийлэнх нь цахилгаан дамжуулах, түгээх болон дулааны эрчим хүч үйлдвэрлэгч компаниуд байна.

Асуулга-5. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үе шатуудад гадаадын хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын аль хэлбэрийг ямар түвшинд баримтлах талаарх бодлого, мөн салбарын нэгдсэн удирдлагын бүтцийг өөрчилж, төвлөрлийг сааруулах эсэх:

Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын бодлогын хувьд цахилгаан, дулаан дамжуулах, түгээх шугам сүлжээний хөрөнгө оруулалтыг улсын, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжаар хийнэ. Эцсийн хариуцагч нь төр байна.

Эрчим хүч үйлдвэрлэх болон хангах үе шатны бүх төрлийн төслүүдийн хөрөнгө оруулалтыг аль болох хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бодлогыг баримтална.

Стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулагчдын сонирхлыг төдийлөн татдаггүй өөрөөр хэлбэл, өртгөө богино хугацаанд нөхөх боломжгүй, барьж байгуулахад урт хугацаа шаарддаг төслүүд, тухайлбал системийн хэмжээний горим тохируулгын зориулалттай байгууламж, усан болон усан цэнэгт цахилгаан станц, "Тавантолгой" ДЦС, ДЦС-2,3-ын өргөтгөл зэрэг нь эрчим хүчний импортыг бууруулах, Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн одоогийн сүлжээнд тэргүүлэх ач холбогдолтой эх үүсвэрийн төслүүдийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

Монгол Улсын эрчим хүчний системийн техникийн нэгдсэн удирдлага ба шуурхай зохицуулалтын хувьд. Монгол улсын эрчим хүчний системийн тасралтгүй, найдвартай ажиллагаа нь нүүрсний уурхайн үйл ажиллагаа, нүүрсний нөөц, төмөр замын бэлэн байдал, тээвэрлэлт, үнэ тарифаас эхлээд станцуудын үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн горим ажиллагаа, тоноглолын найдваржилт, цаг агаарын байдал, хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанаас гадна системд зэрэгцээ холбогдсон ОХУ-ын эрчим хүчний системийн ажиллагаанаас шууд хамаардаг, нэгдсэн цогц систем юм. Эрчим хүчний системийн бүрэлдэхүүн хэсэг болох дээр дурдсан олон эх үүсвэрийн мэдээллийг нэг цагт төвлөрүүлэн боловсруулж,

системийн хэвийн ажиллагаанд нөлөөлөх үзүүлэлтийг тусгайлан бэлтгэгдсэн нарийн мэргэжлийн диспетчер инженерүүд 24 цагийн турш хянаж осол, саатал гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээг авч ажилладаг.

Манай улсын төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ өвлийн оргил ачааллын үед хамгийн ихдээ 1700-1800 МВт (чадлаар) байгаа бөгөөд энэ нь бусад улсынхтай харьцуулахад бага хэмжээ юм. Уг хэрэглээг газар зүйн байрлал, бүс нутгийн хувьд тусдаа бие даасан системүүд болгон задалбал, олон жижиг системүүдийн техникийн параметр үзүүлэлт болох давтамж, хүчдэлийн түвшин зэргийг заасан утгад тогтворжилтийг хангахад хүндрэл үүснэ. Системийн хэмжээнд нэвтрүүлсэн төвлөрсөн автоматикийн систем нь гэнэтийн томоохон аваар саатал гарсан тохиолдолд үүссэн дутагдлын хэмжээгээр хэрэглэгчийн ачааллыг шуурхай хөнгөлж, системийн тогтворжилтийг хангаж тэг зогсолтоос сэргийлэх зориулалттай байдаг.

Мөн манай улсын эрчим хүчний эх үүсвэрүүд нь дулаан цахилгааныг хослон үйлдвэрлэдэг станцуудтай ба дулааны эрчим хүчний хувьд мөн төвлөрсөн дулаан хангамжийн системтэй байдаг. Дулаан, цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэл нь бие биенээсээ харилцан хамааралтай байдаг бөгөөд ДЦС-уудын горим ажиллагааг дулаан, цахилгааны үйлдвэрлэлийг хослуулан төлөвлөж, хэрэгжүүлдэг. Тиймээс цахилгаан дулааны үйлдвэрлэлийн горим ажиллагаанд өвлийн оргил ачааллын үеэр төдийгүй зуны үед эх үүсвэр хоорондын уялдааг хангасан зохицуулалт хийдэг. Тухайлбал, өвлийн улиралд 17:00-22:00 цагуудад цахилгааны хэрэглээ нь үйлдвэрлэлээсээ давсан үед урьдчилан боловсруулсан хөтөлбөрийн дагуу хэрэглээ үйлдвэрлэлтийг тэнцвэржүүлэх арга хэмжээг авдаг ба шаардлагатай тохиолдолд цахилгаан үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дулаан үйлдвэрлэлд шуурхай зохицуулалт хийдэг. Хэрэв цахилгаан, дулааны горим төлөвлөлт нь нэгдсэн зохицуулалтгүй тусдаа өөр өөр байгууллагад шилжвэл дулааны цахилгаан станцуудын хувьд хосолмол үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашигтай байдал алдагдахаас гадна, цахилгаан дулааны уялдаагүй горим ажиллагааг хэрэгжүүлэх болж эдийн засгийн болон техникийн хүндрэл гардаг байна.

Эрчим хүчний нэгдсэн системийн онцлогоос шалтгаалан шуурхай ажиллагааны төвлөрсөн удирдлагатай байх шаардлага үүсдэг.

Асуулга-6. Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл нь эрчим хүчний либералчлалтай уялдаж байгаа эсэх:

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд сэргээгдэх эрчим хүчнээс бусад цахилгаан дулаан үйлдвэрлэх үйлдвэрийн “цогц” төслийн хэрэгжүүлэгчийг салбарын хуулийн хүрээнд шалгаруулах, тусгай зөвшөөрөл олголтод өрсөлдөөн үүсгэх эрх зүйн орчинг бий болгох зорилготой.

Хуулийн зохицуулалтаар төсөл хэрэгжүүлэгчийг эрчим хүч нийлүүлэх үнэ, нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ, нийт хөрөнгө оруулалт зэрэг үзүүлэлтүүдээс тохирохыг сонгон өрсөлдөөн үүсгэн шалгаруулах боломж бүрдэнэ.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд заасны дагуу Монгол Улс нь өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгийг бий болгохын зэрэгцээ эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал хийх асуудлыг тусгасан. Энэ хүрээнд эрчим хүчний томоохон

төслүүдийг цаг алдалгүй эхлүүлэх, суурь горимд ажиллах эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгох, чадлын зохих нөөц бий болгох шаардлага байгаа ч эдгээр төслүүдийг эхлүүлэх эрх зүйн зохицуулалтуудын хэрэгцээ байна.

Асуулга-7. Засгийн газраас Эрчим хүчний зохицуулах хорооны үнэ тариф тогтоох шийдвэрт нөлөөлөхгүй байх, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлэх бодлогыг дэмжих эсэх:

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-д заасан “тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх” бүрэн эрхийг Зохицуулах хороонд олгосон байдаг.

Мөн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын 2.3 дахь заалтад “Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалтад “Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлж улирал тутам шинэчилнэ, үнэ тарифыг улирал тутам индексжүүлсэн байна” гэж заасан.

Үндэсний аудитын газраас Монгол Улсын Ерөнхий сайдад 2021 онд хийсэн “Эрчим хүчний дамжуулалт, түгээлт, үнэ тарицын зохицуулалт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар “Эрчим хүчний тухай хуулиар олгосон Эрчим хүчний зохицуулах хорооны бүрэн эрхийг хараат бусаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах”, 2025 онд хийсэн “Төрөөс эрчим хүчний салбарт баримталж буй бодлого, үнэ тарифын зохицуулалт, өртөг, зардал” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар “Эрчим хүчний тухай хуульд Эрчим хүчний зохицуулах хорооны чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх хууль эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх” зөвлөмжийг тус тус өгсөн.

Монгол Улсын Засгийн газраас Эрчим хүчний зохицуулах хорооноос ирүүлж байгаа эрчим хүчний үнэ, тариф тогтоох, индексжүүлэлтийг санал, дүгнэлтийг хүлээн авч хууль, эрх зүйн зөвлөлөөг өгч хамтран ажилаж байна.

Асуулга-8. Эрчим хүчний салбар дахь хөндлөн татаасны зохицуулалт буюу аж ахуйн нэгжийн үнийг хянаж өндөр тогтоодгийг зогсоох эсэх:

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг болон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс хойш бүхий л хугацаанд айл өрхийн эрчим хүчний тариф өртгөөс доогуур, харин аж ахуйн нэгж байгууллагын тариф өртгөөр буюу өртгөөс өндөр тогтоогдож ирсэн.

Улсын хэмжээнд эрчим хүчний зах зээлийн өнөөгийн тогтолцооны хүрээнд цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээний дундаж өртөг 2025 оны байдлаар 280 төгрөгт хүрээд байна.

Эрчим хүчний зохицуулах хороо нь Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйл (Тариф тогтоох зарчим)-ийн 26.2.1, 26.2.8-д тус тус заасны дагуу уул уурхай болон бусад аж ахуйн нэгж байгууллагын тарифыг бодит өртөг зардалд тулгуурлах, ашгийн зохих түвшинг хангасан байх зэрэг зарчмуудыг баримтлан өртгөөс тодорхой хэмжээнд өндөр тогтоож байна. Харин айл өрхийн тарифыг хэрэглэгчийн төлбөрийн чадавхтай уялдуулан сарын 300 кВт.ц-аас илүү хэрэглээнд бодит өртгөөр, түүнээс бага хэрэглээнд өртгөөс 9-38 хүртэл хувиар доогуур тогтоон мөрдүүлж байна.

Олон жил айл өрхийн тариф харьцангуй доогуур мөрдөгдөж ирсэн тул айл өрхийн жижиглэнгийн тарифыг олон улсын жишгийн дагуу аж ахуйн нэгжийн тарифаас өндөр түвшинд богино хугацаанд хүргэх боломжгүй юм.

Иймээс эрчим хүчний зах зээлийн төвлөрсөн өнөөгийн тогтолцоо хэвээр үргэлжлэх тохиолдолд айл өрхийн тарифыг эхний ээлжинд үе шаттайгаар бодит өртөг хүргэх, эрчим хүчний зах зээлийг задалж өрсөлдөөнт зах зээлд шилжих тохиолдолд нэгдсэн сүлжээний хямд эх үүсвэрээс айл өрхийн хэрэглээг хангах арилжааны тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.

Асуулга-9. “Эрчист Монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн харьяанд үйл ажиллагаа явуулж байгаа эрчим хүчний компаниудын өмнөх жилүүдийн тайлангаар хангалтгүй үнэлэгдсэн, үр ашиггүй, өр төлбөртэй төлөөлөн удирдах зөвлөл, захирал, удирдлагын багт хариуцлага тооцох эсэх, захиргааны болон үйлчилгээний ажилтны тоог зохистой харьцаанд оруулж цомхотгохоор төлөвлөж буй хугацаа:

Төрийн өмчит компаниудын менежментийг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Ерөнхий сайдын холбогдох албан даалгаврууд гарсан.

Үүний эхний алхам болгож энэ оны 8 дугаар сард “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн эзэмшлийн 110 кВ-оос дээш хүчдлийн дамжуулах шугамын ашиглалтыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-нд харьяалуулах Засгийн газрын шийдвэрийг гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Дээрх шийдвэр гарснаар “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК системд томоохон бүтцийн өөрчлөлт орж байна. Энэ онд өмч шилжүүлэх, ажиллах хүчин шилжүүлэх, орон нутгийн цахилгаан түгээх, хангах чиг үүрэг бүхий компаниудыг шинээр бий болгох, систем компаниудыг татан буулгах ажлууд хийгдэж байна.

Мөн төрийн өмчит компаниуд дээр нормативаас давсан илүүдэлтэй ажлын байруудыг цэгцлэх, сул орон тоог цомхотгох зэрэг дотооддоо үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр албан даалгавар өгөгдсөн. Энэ хүрээнд, ЭХЯ-наас “Эрчист Монгол” ТӨХК-тай хамтран төрийн өмчит компаниудын Төлөөлөн Удирдах зөвлөлийн тоог цөөрүүлэх, чиг үүргийг ижил төстэй байдлаар ТУЗ томилох чиглэлээр шийдвэр гаргасан байна. Компаниудын орон тооны нормативыг тодотгох ажлууд хийгдэж байна.

Асуулга-10. Эрчим хүчний тарифын шинэчлэлтийн үр дүнд хэрэглэгчдээс 550 тэрбум төгрөг төвлөрөөд байна. Уг төвлөрсөн хөрөнгийг эрчим хүчний тасралтгүй найдвартай байдлыг хангахад зарцуулах эсэх:

Цахилгаан эрчим хүчний тарифын шинэчлэлийн хүрээнд 546.1 тэрбум төгрөгийн тарифын нэмэлт орлого жилийн туршид бүрдэх бөгөөд энэ нь салбарын олон жил хуримтлагдсан өр авлагыг багасгах, эрчим хүчний тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрүүдийн үнийн зөрүүд дараах байдлаар зарцуулагдаж байна. Үүнд:

1. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ 2025 онд өмнөх оноос 7.4 хувиар нэмэгдэж байгаа ба энэхүү хэрэглээний өсөлтийг 150 МВт чадалтай Бөөрөлжүүтийн цахилгаан станц, 30 МВт-ын чадалтай Тосонцэнгэлийн цахилгаан станц болон 50 МВт чадалтай Багануурын эрчим хүч хуримтлуурын станц зэрэг өндөр үнэ, өртөг

бүхий эх үүсвэрүүдээс хангаж байна. Эдгээр эрчим хүчний шинэ эх үүсвэрүүд болон ОХУ-аас худалдан авч байгаа импортын эрчим хүчний үнийн зөрүүд 108.3 тэрбум төгрөг;

2. Нүүрсний уурхайнууд, төмөр замын тээврийн үнийн өсөлтөд 102.5 тэрбум төгрөг (олон жил алдагдалтай тарифаар нүүрс тээвэрлэж ирсэн “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дотоодын нүүрс тээвэрлэлтийн тарифыг 2025 оны эхнээс алдагдалгүй ажиллахаар шийдвэрлэсэн);

3. Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, компаниудын 13 орчим мянган ажиллагсдын 2023, 2024, 2025 оны цалингийн өсөлтөд 229.8 тэрбум төгрөг;

4. Эрчим хүчний үйлдвэр, компаниудын засвар, шинэчлэл, урт хугацаат зээлийн төлбөрийн өөрчлөлтөд 77.1 тэрбум төгрөг;

5. Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний системд жил бүр олгогдож ирсэн татаасын бууралтыг бүтцийн өөрчлөлт хийх замаар нөхөхөд 28,3 тэрбум төгрөгийг зарцуулж байна.

Оны эхний 8 сарын байдлаар энэ онд төвлөрөх 546.1 тэрбум төгрөгийн 64 хувь буюу 350.8 тэрбум төгрөгийн нэмэлт орлого эрчим хүчний салбарт орж байна.

Асуулга-11. Эрчим хүчний салбарын томоохон төслүүдийг одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиудын дагуу түлхүүр гардуулах гэрээний (ЕРС) нөхцөлөөр хэрэгжүүлэх боломжтой эсэх:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох ёстой ч төсвийн хөрөнгийн хязгаарлагдмал нөөцөөс хамаарч эрчим хүчний хэрэгцээг төрөөс дангаар бүрэн шийдвэрлэх боломжгүй байна.

Нөгөө талаас тендер зарлаж, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах явцад хуулийн шаардлага нь төслийн бодит хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, эрчим хүчний эх үүсвэрийн зураг төсөл, барилга байгууламж, үйлдвэрлэлийн процесс нь хоорондоо шууд хамааралтай ажил, үйлчилгээ бөгөөд үүнийг багцаар нь нэг тендер болгон зарлахад энэ бүх шаардлагыг нэг дор хангаж орж ирэх гүйцэтгэгч байхгүй байна. Иймээс ч нэг багцаар тендерийг үнэлэхэд, гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн хүчин чадлыг хамтад нь тооцох, гүйцэтгэгч нь санхүүжилтээ бүрэн хариуцах нөхцөлийг хуульд тусгах зайлшгүй шаардлага үүссэн. Гэвч, Эрчим хүчний тухай хуулиар тусгай зөвшөөрөл авсан этгээд нь төслийг хэрэгжүүлэхээр байгаа нь бодит байдалд санхүүжилтийн дутагдал үүсгэж байна.

Эрчим хүчний төслүүд нь санхүүжилтийн хувьд асар өндөр өртөгтэй бөгөөд үүнийг төр дангаар санхүүжүүлэх боломжгүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг зайлшгүй шаарддаг. Гэвч, санхүүжилтийн дүнгээс хамаарч хөрөнгө оруулагч нар орж ирэхэд хүндрэлтэй томоохон төслүүдэд стратегийн хувьд ач холбогдлоос хамаарч төрөөс тодорхой хэсгийг санхүүжүүлж болдог. Энэ тохиолдолд тодорхой хувьд нь төрийн санхүүжилт орсон цахилгаан, дулааны том чадлын эх үүсвэрийн төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Иймээс, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалтаар төсөл хэрэгжүүлэгчийг эрчим хүч нийлүүлэх үнэ, нийлүүлэх

цахилгаан эрчим хүчний хэмжээ, нийт хөрөнгө оруулалт зэрэг үзүүлэлтүүдээс тохирохыг сонгон өрсөлдөөн үүсгэн шалгаруулах боломж бүрдэнэ.

Асуулга-12. Багануур, Шивээ-Овоо зэрэг эрчим хүчний нүүрс олборлож байгаа төрийн өмчит хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах, гүйцэтгэх захирлыг улс төрийн нөлөөллөөр томилж байгааг зогсоож, үр ашигт суурилсан менежментийн тогтолцоонд шилжүүлэх эсэх, тус компаниуд нүүрс борлуулах үнээ зах зээлийн зарчмаар бие даан тогтоох нөхцөлийг бүрдүүлэх эсэх:

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани болох “Багануур” ХК, “Шивээ-овоо” ХК нь хувьцаат компани болохын хувьд Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам” болон Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын холбогдох зохицуулалтын дагуу төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг сонгох, чөлөөлөх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байна.

Тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэж буй асуудалд толгой компанийн зүгээс хувьцаа эзэмшигчийн хувиар “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-д заасны дагуу удирдамж өгч ажилладаг болно.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 97 дугаар тогтоолоор “Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд журмын 3 дугаар зүйлд “Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах” асуудлыг зохицуулсан ба журмын 3.1-т “Гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулж, томилно” гэж заасныг удирдлага болгон нэгдлийн харьяанд ажилладаг компаниудын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

- Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлд Зохицуулах хорооны бүрэн эрхийг тодорхойлсон ба хуулийн 9.1.14-т “эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах, тооцоог хянах” гэж заасан байдаг. ЭХЗХ-ны “Түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах” тухай 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 522 тоот тогтоолын аргачлалын дагуу уурхайнуудын үйл ажиллагааны зардлын тооцоог хянадаг ч, нүүрсийг худалдах, худалдах авах үнийг батлахдаа өртгөөс багаар хатуу үнэ тогтоон тооцдог.

“Эрдэнэс Монгол” ХХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК-уудын зүгээс удаа дараа аргачлалын дагуу жил болгон үнийг индексжүүлэн тогтоох асуудлаар холбогдох байгууллагуудад хандаж, үүний үр дүнд ЭХЗХ-ны 2024 оны 12 сарын 06-ны өдрийн 694, 695 тоот тогтоолоор “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК-уудын 2025 оны нүүрсний худалдах үнийг анх удаагаа үйл ажиллагааны өртөгт нь хүргэж баталсан ч 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 167, 168 тоот тогтоолуудаар нүүрсний үнийг 5% бууруулах шийдвэр гаргаснаар дахин өртгөөс багаар үнийг баталсан. Тогтоолоос шалтгаалан 2025 оны хувьд “Багануур” ХК 18 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, “Шивээ Овоо” ХК 8 орчим тэрбум төгрөгийн борлуулалтын орлого алдаж өмнөх жилүүдийн адил санхүүгийн алдагдалтай ажиллаж, хуримтлагдсан өр төлбөр өсөн нэмэгдэхээр байна.

Асуулга-13. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн эрчим хүчний нүүрс тээврийн үнийг төрөөс тогтоож буй асуудлыг шийдвэрлэх, шинэчлэлийн бодлого хэрэгжүүлэх эсэх:

“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн эрчим хүчний нүүрс тээврийн үнэ нь дээр дурдсаны дагуу Өрсөлдөөний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1.2-д тус тус заасны дагуу зүй ёсны монопол байдалтай аж ахуй эрхлэгч тул Монополын эсрэг газар нүүрс тээврийн үнийг хянан зөвшөөрөл олгож байна.

----- оо О оо -----